

Гөөнийгийн Лхүндэв<sup>1✉</sup>, Гончигийн Батболд<sup>1</sup>, Батмөнхийн Цогтбаатар<sup>1</sup>, Такаши Осава<sup>2✉</sup>, Икүэ Отани<sup>3</sup>

<sup>1</sup>Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, Шинжлэх ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

<sup>2</sup>Осака Их сургуулийн Хэл, Соёлын сургууль. Түрэг судлалын салбар. 8-1-1 Аоматани-Хигаши, Минох хот, Осака 562-8558, Япон.

<sup>3</sup>Киото Их Сургуулийн Хүмүүнлэгийн сургууль, Ёошида-хонмачи, Сакёо-ку, Киото 606-8501, Япон.

### Хэрлэн голын сав газраас шинээр илрүүлсэн Түрэгийн язгууртны тахилын онгоны тухай

**Товчлол.** Тус өгүүлэлд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Хэрлэн голын сав газраас шинээр илрүүлсэн хоёр тахилын онгоны малтлага, хавтан чулуун дээрх хээ дүрслэл болон холбогдох он цагийн асуудлыг хөндсөн судалгааны үр дүнг танилцуулж байна. Энэ хоёр дурсгал нь Түрэгийн язгууртны тахилын онгон хэмээх ангилалд хамаарах бөгөөд тахил тайлгын зориулалттай байгууламж юм. Суварган дэгт\*-ийн тахилын онгоныг хээтэй хавтант хашлага, хүн чулуу, зэл чулуу, тахилын сүм буюу асар, сувагтай байгуулжээ. Харин Чойчингийн нуур\*\*-ын тахилын онгоноос зөвхөн онцлог хээ дүрслэлтэй хавтант хашлага, суваг л үлджээ. Энэхүү хоёр дурсгал нь өнөөгийн байдлаар Монгол улсын нутаг дахь Түрэгийн язгууртны тахилын онгоны тархцын хязгаарыг зүүн тийш өргөтгөж байна. Он цагийн хувьд Түрэгийн хожуу хаант улсын төгсгөл үед холбогдохыг лабораторийн судалгаагаар тогтоолгов.

**Түлхүүр үг.** Хүн чулуу, тахилын онгон, хээтэй хавтан чулуу, зэл чулуу, тамга, хээ чимэглэл, Түрэгийн хожуу хаант улс

Lkhundev Guunii <sup>1✉</sup>, Batbold Gonchig<sup>1</sup>, Tsogtbaatar Batmunkh<sup>1</sup>, Osawa Takashi<sup>2✉</sup>, Otani Ikue<sup>3</sup>

<sup>1</sup>Institute of Archeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia.

<sup>2</sup>Osaka University, Graduate School of language and Culture. Suita, Japan.

<sup>3</sup>Kyoto University, Institute for Research in Humanities. Kyoto, Japan

### The newly discovered Turkic memorial complex from the basin of the Kherlen River

**Abstract.** The article discusses the excavation of two memorial complex in the basin of Kherlen River, Bayan-Ovoo, Khentii province. The article also includes an illustration of the engraved stone slabs and related chronology issues. Both complexes belong to the category of Turkic noble memorial complex and are sacrificial structures.

The complex of Suvargan Degt was built with an engraved stone slab, a human statue, a balbal, a sacrificial temple or pavilion, and a trench. However, only the engraved stone slab and the trench remain from the complex of Choichin's Lake.

These two complexes extend eastward the limits of the memorial complex of the Turkic nobles in the territory of Mongolia today. Chronologically, it is related to the end of the Turkic Late Khaganate, according to laboratory research.

**Keywords:** Human statue, memorial complex, engraved stone slab, balbal, tamga, ornament, Later Turkic khaganate

## Удиртгал

Монгол орны нутаг дэвсгэрээс сүүлийн жилүүдэд Түрэгийн үед холбогдох язгууртны тахилын онгон цөөн боловч илэрч олдсоор байна. Энэ нь тухайн дурсгал эрт цагт тоногдон сүйтгэгдэж хөрс шороонд дарагдан хүний нүдэнд төдий л өртөлгүй хоцорч улмаар он цагийн эрхээр мартагдаж үлдсэнтэй холбоотой ажээ. Түрэгийн хаад, язгууртны тахилын онгоныг толгой дараалан эвдэн сүйтгэсэн байдаг нь тухайн дурсгалууд бартаа саад багатай хүн амьтны их хөлийн зам дагуу газарт байрлах, бүтэц зохион байгуулалт, овор хэмжээ зэрэг гадаад харагдах байдлын онцлог, бусад овог аймаг болон дараа үеийнхний санаатай эвдэн сүйтгэх үйл ажиллагаа гэх мэт шалтгаантай холбоотой байсан нь харагддаг.

2021 онд нутгийн иргэдийн аман мэдээний дагуу Хэрлэн голын сав газраас хоёр тахилын онгон шинээр илрүүлж бүртгэн баримтжуулсан юм (Зураг. 1). Одоогоор энэхүү хоёр дурсгал Монгол нутаг дахь Түрэгийн язгууртны тахилын онгон илэрч олдоод буй газар нутгийг зүүн зүгт тэлсэн төдийгүй хамгийн зүүн хойд захад оршиж байна. Тиймээс энд малтлага судалгаа хийх нь шинэ эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, тэдгээрийг харьцуулан үзэх, судалгааны зарим нэг асуудлыг тодруулахад чухал ач холбогдолтой байв. Энэ өгүүлэлд дээрх хоёр тахилын онгоны малтлага судалгаа, бүтэц зохион байгуулалт, хүн чулуу болон хавтант хашлаганы хээ дүрслэл, холбогдох он цагийн асуудлын талаар өгүүлнэ.

## Судалгааны эх хэрэглэгдэхүүн ба арга зүй

*Эх хэрэглэгдэхүүн.* Хэрлэн голын савд орших Суварган дэгт болон Чойчингийн нуурын тахилын онгоны малтлагаас илэрсэн эх баримтууд нь тус өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүн болно.

*Малтлагын арга зүй.* Археологийн шинжлэх ухааны үндсэн арга зүй болох малтлага судалгааны аргыг ашиглав. Ингэхдээ тухайн дурсгалд нэр оноож гол тэнхлэгийн дагуу талбай үүсгэж малтлагыг үе бүрд, олдвор хэрэглэгдэхүүнд зургийн болон бичгийн баримтжуулалтыг зохих арга, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

*Бусад арга зүй.* Тахилын онгоны хээтэй хавтан чулуунаас хэв хуулга авах тусгай зориулалтын цаас (middle paper) болон Solid ink Takuzo Refill Liquid, black, 13803 (60gr) тос ашиглан 1:1 харьцаатайгаар хуулбарлан буулгах аргаар цаасан хэв авав. Түүнчлэн малтлагын талбайн хамгийн доод хөндөгдөөгүй хэсэгт буй малын яснаас тохиромжтойг нь сонгон он цаг тогтоох (C<sup>14</sup>) болон DNA судалгаанд зориулж дээж авсан.

## Суварган дэгтийн тахилын онгон

Энэхүү дурсгал нь Хэнтий аймгийн Баян-Овоо

сумын төвөөс баруун урд зүгт 30 гаруй км-т, Хэрлэн голын хойд эрэг, Суварган дэгт<sup>1</sup> хэмээх багавтар хөндийн өмнөд хэсэгт оршино. Хүн чулуу нь зүүн урагш нүүрэн талаараа унаж зарим хэсэг нь шороонд булагдсан тул хүмүүсийн анхааралд төдий л өртөлгүй өнөөг хүрчээ. Ил буй хэсгийг сайтар ажиглавал өргөн цээж бүхий баруун мөр, баруун гарын тохой хэсэг, бүсэлхий орчимд бүсний товрууны дүрслэл байгаа нь тодорхой мэдэгдэнэ. Хүн чулууны эргэн тойронд эрт цагт ухагдсан хэд хэдэн дугуй хэлбэртэй ором илэрхий хонхойж харагдана. Дурсгалын ойр орчимд шороон далан болон сувгийн ором мэдэгдэхгүй байв.

Малтлага судалгааны үр дүнд энэхүү дурсгал нь язгууртны тахилын онгон болох нь тогтоогдов. Хүн чулуу нь баруун талдаа хээтэй тахилын хашлагатай, зүүн талдаа зэл чулуутай ажээ. Тахилын хашлага болон хүн чулууны гадна талаар зүүнээс баруун тийш 20 м, хойноос урагш 14,5 м хэмжээтэй, 1,0 м орчим гүн, дээд хэсгээрээ 1,2 м өргөн суваг байгааг илрүүлсэн (Зураг. 2). Суваг нь чанх зүүн талдаа 2,0 м гаруй газарт төдий л гүн биш ажээ. Үүнийг бид тахилын хашлага, хүн чулуу руу очих үүдний хэсэг хэмээн таамаглаж байна. Харин сувгаас гарсан шороог ашиглан хийдэг далан нь сувгийн гадна болон дотор талд мэдэгдэхгүй байна.

Хүн чулуу орчимд байгалийн хатуу цагаан хөрснөөс эрс ялгарах зөөлөн хөрстэй байв. Энэ нь дурсгалт газрыг эрт цагт ухаж тоносонтой холбоотойгоос гадна мэрэгч амьтдын хөлөөр чамгүй сүйтгэгдсэн байна. Хүн чулуу тахилын хашлага хоёрын дундах зөөлөн хөрс бүхий нүхнээс шатсан үнс нурам, мал амьтны ясны хэлтэрхий, нимгэн ваарын хагархай гарсан нь тонуулчдын үлдээсэн ул мөр бололтой. Хүн чулууны эргэн тойрны 9 м<sup>2</sup> талбайн өнгөн хэсэгт ургамлын үндсийн хамт нимгэн ваарын хагархай олноор илэрсэн (Зураг. 3). Эдгээр нь өнгөн хөрснөөс доош хатуу цагаан хөрс хүртэл 20 орчим см-т тархсан байв. Энэхүү олон зуун нимгэн ваарын хагархайд тулгуурлан хүн чулууны дээр нимгэн шавар дээвэртэй тахилын сүм буюу асар байжээ хэмээн таамаглаж байна.

Хүн чулууны баруун талд 6-7 м зайд тахилын хашлага нь байжээ. Хавтант хашлага нь хүн чулуунаас доош түвшинд байрлана. Байгалийн хатуу цагаан хөрсийг ухаж хавтант хашлагыг босгож дотор болон гадна талаас нь жижгэвтэр чулуугаар чигжсэн байжээ. Ийм ул мөр өдгөө

<sup>1</sup> Археологийн шинжлэх ухаанд шинэ тутам олдож буй дурсгалыг тухайн дурсгал байрлаж буй газар усны нэрээр нэрлэх явдал түгээмэл байдаг. Бид энэхүү зарчмыг дагаж Хэрлэн голын сав газраас шинээр илрүүлсэн эхний дурсгалыг Суварган дэгт\*, удаах дурсгалыг Чойчингийн нуур\*\*-ын нэрээр судалгааны эргэлтэд оруулж байна. Дурсгалт газрын нэрийг оноохдоо 1970 онд хэвлэгдсэн 1:100.000 масштаб бүхий жанжин штабын газрын зургийн L49-8 дахь талд буй газар усны нэрсээс ашиглав.

баруун, хойд болон зүүн хавтангийн суурь хэсэгт үлдсэн байна. Хавтант хашлаганы зөвхөн суурь хэсэг л үлдэж бусад нь алга болжээ. Бүтэн шахуу үлдсэн ганц зүүн хавтан нь хашлаганы дотор тал руу унаж голоороо цуурч хугарсан байх ажээ. Энэ хавтан нь 130 см өндөр, 195 см урт, 6-8 см зузаан. Хавтант хашлага нь гадна талдаа цэцгэн хээтэй (Зураг. 4).

Тахилын хашлаганы орчмоос ямар нэгэн эд өлгийн зүйл илэрч олдоогүй.

Хүн чулуу: Цагаан шаргал өнгийн боржин чулуугаар өргөн цээж, нарийвтар бэлхүүс, цүдгэр гэдэстэй хүний дүр төрхийг ихэд бодитой урлажээ (Зураг. 5). Хүн чулууны толгойг эрт цагт хуга цохиж хаяжээ. Хүний толгойн дүрслэлийг мэдэх боломжгүй хэдий ч хөшөөний ерөнхий зохиомж, бие эрхтэн болоод эд өлгийн дүрслэл зэрэг нь эр хүйсийн хүн болохыг даруй илтгэнэ.

Хөшөө чулуунд хүнийг босоо байдлаар дүрсэлсэн ба өндөр нь 126 см, өргөн нь цээж

хэсгээрээ 70 см, бүсэлхий орчмоор 45 см бол суурь хэсгээрээ 147 см. Гэдсийг урагш цүдийлгэн урласан бөгөөд тойргийн хэмжээ 123 см. Баруун гараа тохойгоор хагас нугалж энгэртээ цүлхэн бөөртэй сав атгажээ. Зүүн гарыг доош хагас нугалан унжуулж агсарга бүсний дээр тавьж дүрсэлсэн ба гарын сарвууг бадируун томоор гаргасан байна. Хүзүү хэсэгт баруун тал руу нь дарж товчлох зөв энгэртэй дээлийн зах мэдэгдэх бол хоёр ханцуйн эмжээрийг ихэд тод гаргажээ. Дээл болон бүсний хооронд олон хуниас гаргасан нь биед эвтэй өргөн болохыг илтгэнэ. Бүс нь голдоо хөндлөн зураас бүхий дөрвөлжин товруу чимэгтэй бол арал нь цулгуй бололтой. Баруун, зүүн ташаанд бүснээс зүүсэн хэд хэдэн нарийн унжлага дүрсэлжээ. Мөн баруун ташаанд дугуй товч бүхий давхар эмжээртэй дүгрэг хавтагыг чадмаг урласан байна. Хүн чулууны доод хэсгийг өргөн тавиу гаргасан нь хувцасны хормой бололтой. Хормой хэсгээс доош ямар нэгэн

Хүснэгт-1. Янгир тамга бүхий зарим дурсгал

№	Янгир тамга	Дурсгалт газар, товч тодорхойлолт	Зураг
1	Кутлук (Эльтерис) хаан /НТ 683/	Архангай аймгийн Хашаат сум. Номгон 2-р дурсгал. Нэгдүгээр зэл чулууны тамга.	
2	Кутлук (Элтэриш) хаан /НТ 683-692/	Чойрын хүн чулуу. Янгир тамганы хажууд <i>толгой дээрээ сартай могой</i> тамга бий.	
3	Билгэ хааны гэрэлт хөшөө /НТ 716-734/	Архангай аймгийн Хашаат сум. Хөшөө цайдам. Тамганы хувьд хамгийн тэгш хэмтэй бөгөөд сонгодог хэлбэртэйд тооцогддог.	
4	Тэнгри хаан /НТ 735-741/	Архангай аймгийн Ихтамир сум. Бага Хайрхан уулын руни бичээсний хажууд сийлсэн тамга.	
5	Донгойн ширээний дурсгал /НТ 735-745/	Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум. Янгир тамгыг 7 хөшөөнд 16 удаа дүрсэлжээ. Ингэхдээ 9 өөр хэлбэртэй байна.	
6	Талын хөшөө /НТ 735-741/	Хэнтий аймгийн Дархан сум. Талын хөшөөний ар талын дээд хэсэгт сийлсэн тамга.	
7	Чойчингийн нуурын тахилын онгон /НТ 740 оны орчим/	Нуруун дээрээ онгитой янгир тамга. Хэвлий хэсэгт доош шулуун зураас бүхий нэмэлт тэмдэгтэй байна.	
8	Худагтын амны хүн чулуу /Түрэгийн хожуу улс/	Хэнтий аймгийн Мөрөн сум. Янгир тамганы доод талд иштэй хос онги, сэрээ тамга сийлсэн байна.	



өмсгөл мэдэгдэхгүй ба суурь хэсэг нь хавтгай ажээ. Хүн чулууны хадгалалт сайн боловч зүүн гарын тохой, шууны хэсэг, их биеийн ар хормой хэсэг нь хүчтэй өгөршилд орж бутарч хонхойжээ.

Зэл чулуу: Хүн чулуунаас зүүн тийш 13 м-т, сувгийн гадна тахилын онгоны үүдний хэсэгт ганц зэл чулуу байсан нь унажээ. Гонзгой боржин чулууг тэр хэвээр нь ашигласан ба хэмжээ нь 130х30х20 см. Зэл чулуунд ямар нэгэн тамга тэмдгийн дүрслэл үгүй болно.

### Чойчингийн нуурын тахилын онгон

Энэхүү дурсгал нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын төвөөс баруун урд зүгт шулуунаар 28 км-т, Хэрлэн голын хөндий рүү хошуурч орсон өндөр тэгш дэнж дээр оршино. Өнөө цагт уг дэнжийг нутгийн иргэд Бригадын төвийн хошуу хэмээн нэрлэнэ. Энэ нь уг газрын анхны нэр биш бөгөөд социалист нийгмийн үед бригадын төв, хадланчдын бригад, саалийн ферм энд төвлөрч байснаас үүдэж хожим ийнхүү нэрлэгдэх болсон ажээ. Харин дурсгалыг нэрлэсэн Чойчингийн нуур нь энэхүү өндөр дэнжийн баруун хойно нам дор хөндийд орших нэгэн жижиг нуур юм.

Чойчингийн нуурын тахилын онгон нь өндөр дэнжийн дунд хэсэгт байрлана. Тахилын онгон нь уртрагийн дагуу 105 болон 225 хэмд анхны байрлалдаа буй босоо нэг хавтан, түүний өмнө хэвтээ байрлах хоёр дахь хавтант хашлагаас бүрдэнэ. Үлдсэн хоёр хавтант хашлага нь алга болжээ. Тахилын онгоны гадна талаар суваг болон шороон далангийн ором мэдэхгүй байна.

Энэ дурсгалд эртний Түрэгийн язгууртны тахилын онгоны бүтцэд байх хүн чулуу болон зэл чулууг анхнаас нь босгоогүй юу эсвэл хожим алга болсон уу гэдэг нь тодорхойгүй. Ямар боловч энэ дурсгалын орчимд хуучин нийгмийн үед төв суурин газар байсан нь тахилын онгоны зарим бүрдэл хэсэг үрэгдэж алга болсон хэмээн үзэх магадлал өндөр байна.

Малтлага судалгааны үр дүнд тахилын онгон нь гадна талаараа зүүнээс баруун тийш 10,5 м, хойноос урагш 8,0 м хэмжээтэй сувагтай болохыг тогтоосон (Зураг. 6). Суваг нь 0,68-0,82 м гүн, доод хэсгээрээ 0,65-0,92 м, дээд хэсгээрээ 0,80-1,4 м өргөн. Урд болон зүүн сувгийг холбосон малтлагаас харахад тахилын онгоны гадуурх суваг нь гадагш цүлхэн дөрвөлжиндүү хэлбэртэй ажээ. Сувгийн гадна болон дотор талд шороон далангүй.

Дөрвөлжин сувгийн төв хэсэгт ойролцоогоор 1,6-1,8 м урт, 1,0-1,2 м өндөр, 15-25 см зузаан дөрвөн хавтант хашлага бүхий тахилын онгон байжээ. Хойд хавтан нь анх босгосон байрандаа босоо байрлана (Зураг. 7). Тахилын онгоны малтлагаас төмөр зэв, бог малын яс, шавар савны жижиг хагархай, модны жижиг хэсэг, хар

хөх өнгийн паалантай жижиг ваар сав илэрсэн (Зураг. 8). Эдгээр олдвор хэрэглэгдэхүүн 15-30 см зузаан хөрсөнд хадгалагдан үлджээ.

Хэвтээ байх хавтант хашлаганы зүүн хэсгийг саяхан тонуулчид 1,5 м гүн ухжээ. Энэ хэсгийг эрт цагт ч тонуулчид ухсан ул мөр илрэв. Энэ нь хөрс шорооны давхаргын эрс ялгаатай байдлаас гадна эрт цагт ухсан нүхэнд унаж булагдсан боржин чулууны хугархай 1,5 м гүнд цухуйж мэдэгдсэн (Зураг. 9). Уг чулууг гаргаж үзэхэд нэг талыг нь хавтгайлан засаж тэгшилсэн гонзгой боржин чулууны толгой талын хугархай бөгөөд 60х30х30 см хэмжээтэй байв.

Тахилын онгоны баруун, урд, зүүн хойд талд 2,5-3 м зайд тус бүр нэг модон шонгийн үлдэгдэл илэрсэн (Зураг. 10). Эдгээрээс нэг нь харьцангуй бүдүүн 50 см голчтой байв. Тахилын онгоны гадна талаас илрэх модон шонгийн үлдцийг эртний нүүдэлчдийн уламжлалт мал зүлдлэх (гол төлөв адууны арьс шириг толгой, аман хүзүү, туурайн хамт) зан үйл гүйцэтгэж байсны ул мөр хэмээн үздэг. Энэхүү зан үйлийн ул мөрийг батлах адууны толгой, эрүүний яс тахилын онгоны урд, зүүн болон баруун сувгийн доод хэсгээс илэрсэн.

Оршуулга, тахил тайлгад мал амьтан дагалдуулж байсан сурвалжийн мэдээнд НТ 921-922 оны үед Ижил мөрний сав нутгаар аялсан Арабын жуулчин Ахмад Ибн-Фадлан нь огузууд "... Түрэгүүдээс хүндтэй нэгэн нас барахад гэрийн дайтай нүх ухан, талийгчид хувцсыг нь өмсгөж, бүсийг зүүлгэж, намтрыг нь дуудаад гарт нь модон хундагатай дарс бариулдаг. Бүх эд зүйлсийг нь авч ирээд энэ өрөө мэт бунханд нь байрлуулдаг. Дараа нь түүнийг суулгаад нүхнийхээ дээд талыг шавардан бөмбөгөр орой хийнэ. Ингэсний дараа мал амьтад дээр нь очно. Малынх нь тоо толгойноос шалтгаалж 100 эсвэл 200, заримдаа бүр нэг амьтан төхөөрнө. Толгой, шийр, арьс, сүүлнээс бусад махыг нь иднэ. Үлдсэн хэсгүүдийг сэрэгээ-д өлгөн, тавьж, бунхны эргэн тойронд өлгөнө. "Эдгээр нь диваажин руу явахад нь уналга нь болдог" гэж үздэг. Талийгч баатарлаг нэгэн байсан бол алсан хүнийх нь тоогоор, модоор хэлбэр дүрсийг нь гарган, булшны толгойн хэсэгт нь босгодог. "Эдгээр нь түүний боолууд бөгөөд диваажинд түүнд үйлчилнэ" хэмээдэг. Заримдаа тахилга тайлга өргөх амьтадаа (нядлалгүй) нэг хоёр хоногоор хойшлуулдаг..." [Doğan Lütfi, 1954: 65] гэж тэмдэглэн үлдээжээ.

Дээрх сурвалжийн ...Талийгч баатарлаг нэгэн байсан бол алсан хүнийх нь тоогоор, модоор хэлбэр дүрсийг нь гарган, булшны толгойн хэсэгт нь босгодог. "Эдгээр нь түүний боолууд бөгөөд

<sup>2</sup> Саваа модноос арай урт, зузаан нэгэн мод. (*Türk Dil Kurumu Yayınları. Türkçe Sözlüğü. Ankara 2011: 2100*) Мөн араб эхэд *بشخ* буюу "мод" хэмээх үг байна.

диваажинд түүнд үйлчилнэ”... хэмээх мэдээг бид тахилын онгоны зүүн хойд хэсгээс илэрсэн харьцангуй бүдүүн модны үлдэгдэлтэй холбон тайлбарлаж дараах таамгийг дэвшүүлэв. Энэ нь дээрх модны үлдэгдэл нь сэрэгэ үйлдсэн баримт бус харин хүний дүрс сийлсэн модон хөшөө байсан юм биш биз хэмээн үзэж байна. Энэхүү таамгийг дээрх сурвалжийн мэдээ хийгээд дараах баримтад тулгуурлан гаргасан. Тухайлбал, сэрэгэ үйлдэж байсан модон шонгийн үлдэгдлүүд гол төлөв тахилын онгоны хашлаганы дөрвөн буланд эсвэл дөрвөн талаас нь илэрдэг. Харин бидний хүний дүрс сийлсэн хөшөө байжээ хэмээн үзэж буй модны үлдэгдэл нь тахилын онгоны зүүн хойд талд байрлана. Энэ нь сэрэгэ босгох зан үйлийн баримтаас арай жишүү байрлах бөгөөд Түрэгүүдийн хойд нас болон зүүн хойд зүгийг эрхэмлэх үзэл хийгээд булшны толгой талд, диваажинд үйлчилнэ гэсэнтэй утга ижил байна. Нөгөө талаар сэрэгэ үйлдэж байсан шонгийн үлдэгдлүүдтэй харьцуулахад хэмжээний хувьд харьцангуй бүдүүн 50 см голчтой ажээ. Мөн модоор хүний дүрс сийлэх нь илүү амар хялбар байх бөгөөд хэмжээний хувьд ч хүн чулуун хөшөөтэй ойролцоо байна.

Чойчингийн нуурын тахилын онгонд хүн чулуу, зэл чулуу байхгүй боловч язгууртны тахилын онгоны бүтэц бүрэлдэхүүний ихэнх хэсэг, тахил тайлга, эд өлөг тавьсан хэрэглэгдэхүүн олдсоноос гадна таамаглал дэвшүүлэх сонирхолтой баримтууд ч илэрсэн. Эдгээрийн нэг нь эрт цагт тонуулчдын ухсан нүхнээс олдсон засаж тэгшилсэн гонзгой боржин чулууны хугархай болно. Үүнийг тахил тайлгын байгууламжид дорно дахины ард түмний уламжлалт хөшөө босгох соёлын ул мөр болов уу хэмээн таамаглаж байна.

### **Хүн чулууны зарим дүрслэл**

Суварган дэгтийн хүн чулуу нь хийц загварын хувьд бүрэн дүрслэлтэй босоо байрлалтай хөшөө хэмээх ангилалд хамаарна. Энэ төрлийн хүн чулууг VI-VIII зууны үед холбон үздэг.

Бие эрхтэн. Хүний биеийн ерөнхий зохиомжийг өргөн мөр, ханхар цээж, нарийвтар бэлхүүс, үл ялиг цүдгэр гэдэстэй дүрсэлжээ. Зүүн гарын сарвууг бадируун томоор урлажээ. Энэ хүн чулуутай биеийн ерөнхий хийц загварын хувьд тун ойролцоо нэг хөшөө байгаа нь Зүйлийн хөндийд орших Бууралын хөшөө [Баяр, 2001: 65-66] юм.

Сав суулга. Шулуун хүзүү, цүлхэн бөөр, бөөрөнхий ёроолтой. Ийм хэлбэрт сав Түрэгийн хүн чулуунд түгээмэл дүрслэгдсэн байдаг. Савны амсарт 3,0 см орчим голч бүхий гүн биш хонхор гаргажээ.

Бүс. Хүн чулуунд дөрвөлжин товруу чимэг, цулгуй аралтай агсарга бүс дүрсэлжээ. Агсарга бүс

нь байнгын хөдөлгөөнт амьдралын хэвшил бүхий анчин, нүүдэлчдийн хувьд хэрэгцээт зүйлсээ биедээ ойр авч явахад нэн тохиромжтой хэрэгсэл юм. Бүснээс элдэв зэвсэг болон бусад эд зүйлсийг агсаж зүүх зориулалттай хэд хэдэн унжлагыг дүгрэг хэлбэрт хавтаганы хамт дүрсэлсэн байна.

Бүсний дөрвөлжин товруу нь доод талдаа хөндлөн амтай ба товруу бүрийг хооронд нь заагласан байх ажээ (Зураг. 11). Ийм товруу чимгээр бүсийг нэлэнхийд нь чимжээ. Харин бүсний арал орчмын хэсэг нь арай жижиг бөгөөд дүрслэл нь тодорхойгүй.

Дөрвөлжин товруу чимэг нь цулгуй, голдоо урт болон богино хэрчлээстэй, унжлага зүүх сэтэрхийтэй байхаас гадна дөрвөлжин товруунуудыг нийлүүлж залгасан, товруу тус бүрийг заагласан нэг болон хоёр зураастай гэх мэт хэлбэртэй байна. Дөрвөлжин товруу чимэгтэй бүсийг Түрэгийн эхэн үеийн хэлбэр хэмээн үздэг ба НТ-ын VII-IX зууны үед [Баяр, 1997: 55] хамаарах хүн чулуу болон бусад дурсгалуудад ч тохиолддог байна. Бидний толилуулан буй Суварган дэгтийн хүн чулуунд дүрсэлсэн товруутай адил хүрэл? товруу чимэгтэй бүс Уулын Алтайн Юстед голын хөндийн 24-р дурсгалт газрын 13-р булшнаас олдож байжээ (Зураг. 12). Булшны он цагийг VIII зууны эхэн хагаст холбогдоно [Кубарев, 2005: 50-51] хэмээн үзжээ.

Бүснээс зүүж дүрсэлсэн нэг эдлэл бол хавтага юм. Хавтагыг баруун ташаанд бүснээс зүүж дүрсэлсэн ба дүгрэг хэлбэртэй, давхар эмжээртэй ба голдоо дугуй товчтой. Энэ нь эртний Түрэгийн хүн чулуунд байх дүгрэг хавтагатай хэлбэрийн хувьд ижил төстэй боловч голдоо дугуй товчтой байгаагаараа ялгарна.

Бүснээс зүүсэн өөр нэг эдлэл бол унжлага юм. Зүүн ташаанд ижил урттай хоёр хос, баруун ташаанд хавтаганы хойно ижил урттай хос унжлага нэгийг, урд талд нь арай уртавтар унжлага нэгийг тус тус дүрсэлжээ. Бүгд цулгуй бөгөөд гонзгой шулуун хэлбэртэй. Эдгээр унжлагаас зэр зэвсэг, бусад дагалдах хэрэгсэл болон элдэв зүйл агуулах хавтага сав зэргийг зүүх зориулалттай бөгөөд эдгээр нь бүгд өөрийн тогтсон дараалалтай байсан нь харагддаг.

### **Тахилын хавтант хашлаганы хээ дүрслэл**

Тахилын онгоны хавтант хашлаганы хээ дүрслэл нь Монгол нутагт буй Түрэгийн язгууртны тахилын онгоны хашлаганы хээ угалз, дүрслэлтэй ижил төстэй. Хавтангийн төв хэсэгт цэцэг навч болон нүүдэлчдийн бодит ахуй амьдралыг харуулсан дүрслэл, зах хэсгээр нь геометрийн болон ургамлын гаралтай хээ дүрсийг урласан байна. Эдгээр хээ дүрсийг нарийн зураасаар цоолборлон урлах аргаар гаргажээ.

Суварган дэгтийн тахилын онгон. Тахилын онгоны ганц хавтант хашлага нь гадна талдаа цэцгэн хээтэй (Зураг. 13). Хавтан чулууны гадна талыг жигд тэгшлээд төв хэсэгт зэрэгцүүлэн хоёр цэцгэн хээ дүрсэлсэн байна. Цэцгэн хээ нь голдоо дугариг бүхий дөрвөн дэлбээтэй. Уг дэлбээний дөрвөн уулзвараас ишилсэн зууван дөрвөн нахиатай. Эдгээрийн гадуур мөн дөрвөн дэлбээг давхарлан сийлжээ. Дотор талын дэлбээг угалзруулсан бол гадна дэлбээг хагас дугуйруулан шулуунаар дүрсэлжээ. Гадна дэлбээний уулзвар бүрд чандмань хэлбэрт үүлэн хээг тус тус сийлсэн байна. Хавтангийн хоёр цэцгэн хээг шулуун зураасаар холбогдсон адил талт давхар гурвалжин дүрсээр зааглажээ. Цэцгэн хээний гадуур, хавтангийн хоёр хажуу болон дээд ирмэгийн дотор талаар давхар “П” үсэг хэлбэртэй хоорондоо 15 см зайтай шулуун татжээ. Энэхүү шулуун хүрээний дотор талыг эвэр? угалз хээгээр битүү сийлж чимсэн байна.

Чойчингийн нуурын тахилын онгон. Хавтант хашлаганы зарим дүрслэл нь он цагийн эрхэнд ихэд бүдгэрч баларчээ. Хавтангийн гадна талыг жигд тэгшлэн зассан ба хээ дүрслэлийг нарийн зураасаар сийлж урласан байна. Цаасан хэв хуулганаас харахад босоо хавтангийн гадна талд хоорондоо огтлолцсон битүү шулуун зураас татаж төв хэсэгт нь дөрвөн дэлбээт цэцгэн хээ, гадна талаар нь хамар угалз болон чандмань хэлбэрт үүлэн хээг тус тус дүрсэлсэн байна. Хээний гадуур хавтангийн хоёр хажуу болон дээд ирмэгийн дотор талаар давхар “П” үсэг хэлбэртэй шулуун татжээ. Үүний хоёр хажуугийн босоо шулуун дотор суурьгүй адил талт гурвалжин дүрсийг эгнүүлж, дээд хэсгийг хамаг угалз хээгээр битүү сийлж чимсэн байна. Хавтангийн доод газарт суулгах хэсэг нь цулгүй ажээ (Зураг. 14).

Харин нөгөө хэвтээ хавтанд ихэд сонирхолтой дүрслэл сийлжээ. Хавтангийн төв хэсэгт өндөр цамхраа бүхий тооно, өндөр хана, бөмбөгөр оройтой гэрийн ерөнхий тэгийг хажуугаас харсан байдлаар дүрсэлжээ (Зураг. 15, 16). Гэрийн хойморт нүүрэн талдаа уулан хээ бүхий урт сэнтий дээр завиалан суусан эр, эм хүн дүрсэлсэн байна. Баруун гар талд сууж буй хүн нь эмэгтэй бололтой. Тэрээр өндөр шовгор оройтой малгай өмсөж баруун гараар цээжний өмнө дэрвэгэр амсартай цом хэлбэрт аяга барьжээ. Харин зүүн гараар зүүн талд нь завиалан сууж буй хүнтэй хөтлөлцсөн байна. Зүүн талын хүнийг зузаан дугуй хүрээтэй (саравч), өндөр шовгор орой бүхий малгайтай дүрсэлжээ. Малгайн шовгор орой баруун тийш бага зэрэг хазайсан байна. Тэрээр баруун гараар бүсгүйтэйгээ хөтлөлцсөн бол зүүн гараар цээжний өмнө аяга барьжээ. Энэ нь тахилын онгоны хавтант хашлаганд орд өргөөндөө

эзэн, эзэгтэйг дүрсэлсэн анхны тохиолдол юм.

Гэрийн зүг зүүн талаас нь бурантгаа унжуулан ирж буй тэмээ хөллөсөн хоёр дугуйт сүйх тэрэг дүрсэлжээ. Сүйх нь гурвалжин оройтой, хажуу талдаа гэгээвчтэй. Энэ дүрслэлийн дор дээрээ онги бүхий янгир тамгыг тус тус дүрсэлсэн байна. Гэрийн гадна баруун талд өөр дүрслэлүүд ч байжээ. Харамсалтай нь хавтангийн баруун доод хэсэг хагарч алга болсон тул анх ямар дүрслэл байсныг бүрэн таних боломжгүй болжээ. Ямартай ч зогсож буй хоёр хүний хэлбэр төрх тодорхой мэдэгдэнэ. Гэрийн гадна дээд хэсгийг хамар угалз болон чандмань хэлбэрт үүлэн хээгээр дүүргэсэн бол хавтангийн хоёр зах, дээд хэсгийг өмнөх хавтангийн адил дүрсийг сийлсэн байна.

Хавтангийн хээг ажиглахад хээ угалз, цэцэг навчаар тэнгэр газар буюу хүрээлэн буй орчныг билэгдсэн, хүн амьтан хийгээд бусад бодит дүр дүрслэлүүд нь тухайн үеийн нүүдэлчдийн ахуй амьдралын хэв маягийг бүрэн төлөөлж чадахуйц байгаа нь хийсвэрлэл болон бодит байдлыг чадварлаг хослуулсан, гүн гүнзгий утга агуулгыг илэрхийлсэн зохиомжит дүрслэл болох ажээ.

Язгууртны тахилын онгоны хавтант хашлаганд байх дүрслэлийг ерөнхийд нь дөрөв ангилсан [Battulga, 2016: 232-233] байдаг. Эдгээрийн дотроос ургамлын дүрс болох цэцэг навч дүрсэлсэн нь олонтоо тохиолддог. Харин хүн дүрсэлсэн тохиолдол ганцхан байжээ. Тэр нь Хөл Асгатын дурсгал юм. Хөл Асгатын дурсгал нь хүн чулуугүй бөгөөд хавтан чулуунд гурван хүний дүрс товойлгон сийлсэн байдаг [Баяр, 2001: 119].

Бидний толилуулан буй Чойчингийн нуурын тахилын онгоны хавтан дээрх дүрслэлтэй тун төстэй нэгэн дурсгалыг Өмнөд Казакстаны нутаг Когалы хэмээх газраас 2007 онд илрүүлжээ (Зураг. 17). Тэнд хойноос урагш цуварч таван тахилын хашлага байрлах ажээ. Түүний хоёрдугаар тахилын хашлаганы хөшөө чулууны дээд хэсэгт хүний толгойн дүрс, цээжин хэсэгт дөрвөн тамганы хамт өндөр цамхраа бүхий гэрийн хойморт завиалан сууж буй гэрийн эзэд (эр, эм)-ийг дүрсэлжээ [Рогожинский, 2010: 339-340]. Мөн Вэнжи гүнжийн түүх: "Ху-гийн цуур хэмээх арван найман бадаг" шүлэгт зориулж Мин улсын үеийн нэгэн зураачийн цуврал бүтээл [邱靖嘉, 2021: 48-52]-д Ляо болон Тан улсын үеийн умардын нүүдэлчин язгууртнуудын ахуй амьдралын дүр төрхийг 18 бадаг шүлэг бүрд зургаар хавсарган дүрсэлсэн байдаг (Зураг. 18). Тус зураг дахь нүүдэлчдийн ахуй амьдралын хэв маяг, хувцас хэрэглэл, гэр орон сууц, уналга хөсөг, эд хэрэглэл зэрэг нь Чойчингийн нуурын тахилын онгоны дүрслэлтэй ижилсэх ба өнөөгийн байдлаар Монгол улсын нутагт буй дундад эртний үеийн түүхийг сэргээн үзэх чулуун урлалын ганц төлөөлөл болж байна.



Ерөөс Түрэгийн үеийн хүн чулуу, тахилын хавтан болон тэдгээрт сийлсэн элдэв хээ дүрслэл, тамга тэмдэг нь тухайн цаг үеийн чулуун урлалын хөгжлийг илэрхийлэх чухал баримтын нэг мөнөөс гадна тэр үеийн хүмүүсийн ахуй соёл, овог аймгуудын угсаа гарвал, эзэмшил газар нутгийн байршил зэргийг судлах үндсэн эх хэрэглэгдэхүүн болсоор ирсэн юм.

### Он цагийн асуудал

Хэрлэн голын сав болон Монгол орны тал хээрийн бүс нутагт буй Түрэгийн язгууртны тахилын онгонууд, тэдгээрийн гадаад бүрдэл хэсгүүдэд ялгаатай байдал нэлээд ажиглагддаг. Энэхүү ялгаатай байдлыг тодруулах, археологийн малтлага судалгааны үр дүнг баталгаажуулахад үнэмлэхүй он цаг тогтоох шаардлагатай байсан тул тахилын онгоны олдвор хэрэглэгдэхүүнээс зохих дээжийг авч Япон улсад лабораторийн шинжилгээнд илгээсэн юм.

Суварган дэгтийн тахилын онгон нь тоногдож ихэд сүйтгэгдсэн тул анх бүтээн босгоход хийсэн он цаг тогтоох боломжтой дээж хэрэглэгдэхүүн илрүүлж чадаагүй. Харин хүн чулуу болон тахилын онгоны хоорондох зайд хоёр нүх илэрсэн. Түүний том нүх (дээд хэсгээрээ 1,5 м голчтой, 1,0 м орчим гүн)-ээс бог малын чөмөг болон хавирганы ясны хугархай хэд хэд илэрч тэндээс дээж сонгон лабораторийн шинжилгээнд илгээсэн юм. Шинжилгээний үр дүнд 773-885 он (calAD, 95,4%, ТКА-26290)-ы хооронд холбогдохыг тогтоосон (Зураг. 19).

Энэхүү он цагийн хамаарал нь тухайн дурсгалыг бүтээж босгосон бус харин эвдэлж сүйтгэгдсэн цаг хугацааг илэрхийлж байна хэмээн үзсэн. Учир нь тухайн нүх тахилын онгоныг анх бүтээж босгосонтой холбоогүй бөгөөд харин тонож сүйтгэх явцад бий болжээ. Нүхнээс үнс нурам, малын ясны хугархай, нимгэн ваарын хагархай холилдсон байдалтай олдсон. Эндээс олдсон нимгэн ваарын хагархай нь хүн чулууны дээрх модон багана бүхий тахилын сүм буюу саравчны дээврийн ваартай ижил байгаа нь эвдэрч нурсны хойно дээрх нүхэнд орсон болохыг харуулж байна.

Чойчингийн нуурын тахилын онгон мөн л эрт цагт тоногдож сүйтгэгдсэн боловч хашлаганы төв хэсэг болон суваг дотор он цаг тогтоох дээж хэрэглэгдэхүүн хангалттай үлдэж хоцорсон байв. Эдгээрээс тахилын онгоны төв хэсгээс илэрсэн бог малын ясыг сонгон он цаг тогтоох шинжилгээ хийлгэж 671-777 он (calAD, 95,4% ТКА-26289)-ы хооронд холбогдохыг тогтоов (Зураг. 20).

### Тахилын онгоны эзэн

Энэхүү хоёр дурсгал нь нэг голын савд хаяа дэрлэн орших ба төрөл болон зориулалтаар

ижил, он цагийн хувьд ойролцоо тул нэг угсаатанд хамаарах нь тодорхой юм. Харин хэн гэдэг язгууртанд зориулж босгосон болохыг нарийвчлан тодруулах бичиг үсгийн зүйл алга байна. Ямартай ч хавтан чулууны хээ дүрслэл, хүн чулуу, тамга тэмдэг зэрэг нь тахилын онгоны эздийг язгууртан хүн болохыг илтгэнэ.

Янгир тамга нь Түрэгийн төрийн эрх барих Ашина (Эшир) овогт хамаарна. Янгир тамгыг тогтсон нэг загвартай бус хоорондоо ялгарах хэд хэдэн хувилбартай дүрсэлсэн байдаг. Үүнээс гадна янгир тамгыг өөр тамгатай хамтад нь нийлмэл байдлаар дүрсэлсэн нь бидний толилуулан буй дурсгалд тохиолдож байна.

Бид янгир тамганы олон хувилбарыг нягтлан үзэхэд Бага Хайрханы дурсгал [Рогожинский, Тишин, 2021: 585-587]-ын нуруун дээрээ онги бүхий янгир тамга нь Чойчингийн нуурын тахилын онгоны тамгатай тун төстэй ажээ. Энэ нь уг хоёр дурсгалыг холбон үзэх сэжиг бөгөөд Бага Хайрханы дурсгалд буй янгир тамга нь хожуу Түрэгийн Тэнгри хааны тамга болохыг тогтоожээ. Энэ тухайд, *Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дахь, эртний Түрэгийн түрүү ба хожуу улсын хаан, язгууртны хэд хэдэн онгон цогцолсон Баян Цагааны хөндийн ойролцоох Бага Хайрхан хэмээх уулын хаднаа “Хамаг иргэнд төр нь Тэнгри хаан байлаа”, “Тэнгри хааны эзлэмэ алгинч нь Өтүкэнд суухгүй” хэмээн сийлсэн хоёр бичээс юм. Энэ хоёр бичээст гарч буй Тэнгри хаан нь Билгэ хаанаас хойш хаан өргөмжлөгдсөн түүний хүү, нангиад сурвалжийн Тэн-ли хаан мөн болохыг, Тэнгри хааны нэр уг хэлбэрээрээ анх удаа Төв Азийн сурвалжид тохиолдож [Munkhtulga, 2010: 47] байгааг дурджээ. Түрэгийн төр хямарч улс гэр доройтох үед Билгэ хааны хатан Кутлуг По-фу, И-рань хааны татвар хатан, Тэнгри хааны гүнж, баруун шад зэрэг ихэс язгууртнууд дайснаас зугтан дүрвэж Тан улсад очиж хоргодсон төдийгүй албан ёсоор дагаар орсонд Тан улсын Сюань-зун хаан (713-756 онд төр барьсан) олзуурхан баясаж бараг хоёр зуун жилийн турш амар тайван байлгаагүй эртний дайсан бүрмөсөн бууж өгсөн түүхэн чухаг үйл явдалд зориулж дээдсийнхээ сүмд тахил өргөн шүлэг хүртэл бичиж байв. Түрэгийн хааны Ашина ургийн язгууртнууд Өтүкэн буюу одоогийн Монгол улсын нутаг Хангайн нуруунаас Тан улсын зүг дүрвэн явахын өмнө, төр нь сэргэхээ нэгэнт өнгөрснийг ойлгосноо, эргэн ирж чадахгүйгээ мэдэрч байснаа, ирэхгүйгээр шийдчихсэн байснаа гутаж цөхөрсөн байдалтайгаар өгүүлж эрх мэдлийн бэлгэ тэмдэг болсон тамгынхаа хамт сийлүүлэн үлдээсэн нь Хангайн нуруунд тийнхүү түүхэн хэргийн гэрч болон хоцорчээ [Мөнхтулга, 2010: 142-149; Munkhtulga, 2010: 47-48] хэмээн дүгнэжээ.*

Энэхүү дүгнэлт болон Чойчингийн нуурын тахилын онгоны тамга, хамаарах он цаг зэрэг нь Түрэгийн хожуу хаант улсын төгсгөл үеийн сүүлчийн дүрвэлтэд Ашина овгийнхон бүгд нүүлгүй зарим нь өөрсдийн хараат Хэрлэнгийн арын, зүүн талын худ ураг болох нэг (Г.Б-Татар)-нийг зарим нь түшсэн байж болох юм. Тиймээс энэ насандаа хаан сэнтийд заларч чадаагүй Түрэгийн алтан ургийн залгамжлагчийг нөгөө ертөнцөд ноёлон суухыг бэлгэдэн ийнхүү дүрсэлсэн байж болох юм хэмээн таамаглаж байна.

### Хэлэлцүүлэг

Тахилын онгон нь үүрэг зориулалтын хувьд нэгдмэл боловч олон бүрдэл хэсэг бүхий нарийн бүтэц зохион байгуулалт бүхий дурсгал болохыг олон жилийн турш хийсэн судалгааны явцад нэгэнт тогтоожээ. Энэхүү олон бүрдэл хэсгийн зарим ялгаатай байдал, дурсгалын овор хэмжээ, хэлбэр хийц зэрэг нь тухайн онгоны эзний гарал угсаа, нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлж байгааг судлаачид өөрсдийн ном бүтээлдээ тусгасан байдаг [Войтов, 1996; Мөнхтулга, 2019].

Хэрлэн голын савд малтсан язгууртны хоёр тахилын онгоны хэрэглэгдэхүүнийг өмнө нь хуримтлагдсан ижил төстэй материалтай харьцуулан үзэхэд ижил төстэй зүйлээс гадна зарим нэг онцлог ялгаа байна. Тухайлбал, энэхүү хоёр дурсгал нь ОХУ-ын судлаач В.Е.Войтовын 1996 онд нийтлүүлсэн “Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв” бүтээл дэх ангиллын III төрөлд холбогдож болохоор байна. III төрлийн онцлог шинж нь дөрвөн хавтант ганц хашлагатай, далан суваггүй. Гол тэнхлэг нь баруун зүүн чиглэлтэй, зэл чулуу нь зүүн талдаа байна. Он цаг нь VII зууны сүүл, VIII зууны эхэн хагаст холбогдоно [Войтов, 1996: 61] хэмээн тодорхойлжээ. Тэрээр III төрлийг дотор нь дэд төрөл, хувилбар хэмээн нарийвчлан ангилжээ. Энэхүү ангиллаар Суварган дэгтийн дурсгал III төрлийн III-A дэд төрөл, III-A-а хувилбар (хашлага нь хээтэй хавтантай, хүн чулуутай, зэл чулуутай)-т, харин Чойчингийн нуурын дурсгал нь III төрлийн III-B дэд төрөл, III-B-б хувилбар (хашлага нь хээтэй хавтантай)-т хамаарч байна.

Дээрх тахилын онгоны ангиллын III төрөлд байх зарим онцлог шинж судалгаа шинжилгээний ажил өргөжихийн хэрээр өөрчлөгдөж болохоор байна. Эхнийх нь далан сувгийн тухай асуудал юм. Монгол орны нутагт буй Түрэгийн язгууртны зарим тахилын онгонд далан суваг байгуулсан ором огт мэдэгддэггүй. Гадаад байдлын энэхүү шинжид тулгуурлан далан суваггүй хэмээн ангилж иржээ. Харин Хэрлэн голын савд малтсан хоёр тахилын онгоны судалгааны үр дүнд далангүй

боловч сувагтай болохыг тогтоогоод байна.

Дараагийн нэг асуудал бол тахил шүтээний сүмийн тухай юм. Тахил шүтээний сүмийг овор хэмжээ ихтэй, том бүтэц бүхий хаад язгууртны цогцолборт босгодог хэмээн үзэж байв. Харин бидний хийсэн малтлага судалгааны үр дүнд энэхүү үзэл баримтлал өөрчлөгдөж болохоор байна. Суварган дэгтийн дурсгалаас нимгэн ваарын хагархай ихээр илэрсэн. Үүнтэй ижил төстэй хэрэглэгдэхүүн Олон нуурын хөндийн дурсгалаас ч олдож байжээ. Үүнийг тахилын хашлаганы орчмоос дээврийн ваарын хагархай илэрсэн нь тэнд тахилын сүм буюу асар байсныг илтгэнэ [Баяр, Мөнхтулга, Хүрэлсүх, 2008: 108] гэжээ. Эндээс үзэхэд Түрэгийн хаан угсааны өндөр дээд сурвалжтанаас арай доогуур зэргийн язгууртны тахилын онгонд ч тахил шүтээний сүм барьж байгуулж байжээ. Гэхдээ энэхүү тахилын сүм нь хаад язгууртны шиг өндөр тавцан, чулуун багана, тоосгон ханатай бус модон багана бүхий вааран дээвэртэй, асар-саравч хэлбэртэй байсан бололтой. Суварган дэгтийн дурсгалд тахилын сүм нь хүн чулууны дээр байсан нь ваарын тархцын хэмжээгээр тодорхой мэдэгддэг. Үүнтэй дүйцүүлж болох нэгэн мэдээ байдаг нь Оросын алдарт судлаач Г.Н.Потаниний тэмдэглэл юм. Тэрээр 1870-аад оны сүүлчээр Монгол орны баруун хэсэгт орших Даян баатар хэмээн алдаршсан хөшөөг очиж судлах үед хөшөөн дээр хаалга, цонхтой жижиг дуган хэлбэрийн байшин бариастай, хадаг яндар болсон шүтлэгийн зориулалттай газар байсан [Баяр, Эрдэнэбаатар, 1999: 35-36]-ыг тэмдэглэн үлдээсэн байдаг.

Монгол орны зүүн бүс нутагт буй Түрэгийн язгууртны тахилын онгонууд нь бүгд эвдэгдэн сүйтгэгдэж анхны хэлбэр төрхөө алдсан байдаг. Энэ нь тахилын онгоны бүтцэд байх олон бүрэлдэхүүний заримыг анхнаас нь босгоогүй байсан уу эсвэл хожим эвдэгдэж алга болсон уу гэдэгт эргэлзээ төрүүлдэг. Эрт үеийн хөшөө дурсгалыг дараа үеийн хүмүүс ямар нэгэн байдлаар эвдэж гэмтээх, байрнаас нь зөөж өөр газарт аваачих, өөр зорилгоор ашиглах үзэгдэл хүн төрөлхтний бүх түүхийн туршид байсан талаар судлаачид янз бүрийн баримтад тулгуурлан тайлбарладаг [Баяр, 2017: 21]. Суварган дэгтийн дурсгалыг цаг хугацааны хувьд 800-аад оны үед сүйтгэгдсэн болохыг тогтоосон нь ямар боловч дараа үеийнхэн нь эвдэж гэмтээж байсан гэх тайлбарыг гэрчлэх нэгэн баримт болж байна.

Хэрлэн голын сав болон Монгол орны зүүн бүс нутаг нь Түрэгийн үеийн дурсгал тэр дундаа язгууртны тахилын онгон ховорт тооцогдож байв. Үүнийг тус бүс нутагт хайгуул судалгааны ажил бага хийгдсэн, томоохон дурсгалууд нь нүүдэлчдийн төрийн голомт нутаг Хангай нуруу,



Монгол орны төв хэсгийн том, жижиг голуудын саваар төвлөрч байсантай холбон үзэж байжээ. 1990-ээд оноос хойш тодорхой зорилго чиглэлтэй хийгдсэн хайгуул судалгааны үр дүнд Түрэгийн хожуу хаант улсын үед холбогдох язгууртны тахилын онгон хэд хэд илэрч олдсон. Эдгээр дурсгалаас сүүлийн жилүүдэд гадаад улстай хамтарсан төслийн хүрээнд малтан судалж үр дүнг нь урьдчилсан байдлаар хэвлэн нийтлээд байна. Үүний эхнийх нь Донгойн ширээний дурсгал [Цогтбаатар нар, 2017: 12-94; Radiocarbon .., 2015: 1-6; Radiocarbon .., 2017: 1-5] бол удаах нь Хэрлэн голын сав дахь Хаяа худгийн тахилын онгон [Баяндэлгэр нар, 2022: 60-61] юм. Дараагийнх бидний толилуулан буй Суварган дэгт болон Чойчингийн нуурын дурсгал болж байна.

Үүнээс гадна зарим дурсгалын гадаад хэлбэр, бүтэц зохион байгуулалт, хүн чулуун хөшөө, тахилын хавтант хашлага, тамга тэмдэг, бичиг үсэг зэрэгт тулгуурлан тухайн дурсгалын эзэн холбогдогч хийгээд хамаарах он цагийн талаар илүү нарийвчлан дүгнэсэн нь бий [Батсүрэн, Мөнхтулга, 2017: 141; Мөнхтулга, Оосава, 2015: 53-54; Мөнхтулга, Бүрэнтөгс, Арьяажав, 2019: 5-48]. Тухайлбал, Монгол орны зүүн хэсэгт буй Түрэгийн үед хамаарах дурсгалын хамгийн эртнийх нь Чойрын хүн чулуу болж байна. Уг хүн чулууны бичээст нэр нь дурдагдаж буй Илтириш Кутлуг нь Түрэгийн хожуу хаант улсыг 682 оны сүүл 683 оны орчимд байгуулж хаан суусан бөгөөд 692 оны намар насан эцэслэжээ.

Дээр нэр дурдагдсан дурсгалууд нь Түрэгийн хожуу хаант улс байгуулагдсан 680-аад оноос хойш холбогдох ажээ. Мөн тус бүс нутгаас илэрсэн Түрэгийн язгууртны тахилын онгон, Түрэг бичээс, тамга тэмдгийн дурсгал дотор Ашина (Эшир)-ийн янгир тамга болон түүний олон хувилбар байгаа нь ихэд сонирхолтой.

Тамга дүрслэх тогтсон уламжлал Түрэг бичгийн их бага дурсгал болон хүн чулуу, мэлхий чулуу, тахилын хавтант хашлага зэрэгт тусгалаа олсон байдаг. Харин тухайн дурсгалд аль тамга нь голлож буйгаас шалтгаалан тухайн овог давуу байр суурь эзэлж байгаа нь тодорхойлогддог ажээ. Эндээс үзэхэд Хэрлэнгийн дунд бие орчим нь онги болон янгир тамгатын эзэмшил нутаг байж болохоор харагдана. Хэрлэн голын сав нутаг нь VI зууны сүүлээс VII зууны дунд үе хүртэл Токуз татарын нутаг [Батсүрэн, 2009: 53], Түрэгийн хаант улс төрийн голомтоо дахин сэргээж Өтүкэнд шилжсэн цагаас хойш түүний дорнод хэсэг буюу Хангайн нуруунаас зүүн тийш Татарууд [Билэгт, 2015: 69-70], Түрэг улсын зүүн гарын (төлис?) 12 бүлэг овог аймаг [Батсүрэн, 2015: 71], Баегү (Байырку) аймаг [石見清裕, 2014: 1-16]-т харьяалагдах нутаг байсан талаарх

олон мэдээ баримт, судлаачдын таамаглал байна. Түрэгийн хожуу хаант улс байгуулагдсан болон уруудан доройтох үеийн түүхэн цаг хугацаа нь дайн самуун ихтэй, овог аймгууд бусдын эрхшээлд орох, салж гарах, шахагдаж өөр тийш нүүдэллэх зэргээр тогтворгүй байсан нь түүний бүрэлдэхүүнд байсан түрэг, теле аймгуудын байршлын түүхэн газар зүйн асуудал харилцан адилгүй байгаагаар тодорхойлогдож байна. Нөгөө талаар Хэрлэнгийн сав нутаг дахь археологийн дурсгалууд дотор тухайн үеийг илэрхийлэх дурсгал ховор байгаа нь үүнийг давхар нотолно. Ямартай ч археологийн дурсгал болон газар орны байршлаар нь мөшгөвөл Түрэгийн хожуу хаант улсын янгир тамгатын зарим язгууртнууд улс орон нь бутран доройтож уруудах үедээ нүүдэлчдийн улс төрийн төв Өтүкэнээс зайлсхийж Хэрлэнгийн дунд биеийн нэг (Г.Б-Татар)-эн аймгийг түшиж хэсэг хугацаанд суурьшиж байжээ хэмээн үзэхэд хүргэж байна. Энэхүү таамаглалыг дэвшүүлэх нэг сэжим Түрэгийн хааны ургийн янгир тамга юм. Чойчингийн нуурын дурсгалтай хөрш зэргэлдээ орших нэгэн цаг үед бүтээгдсэн Донгойн Ширээ болон Талын хөшөөний дурсгалд онгин тамганы олон хувилбарын хамт янгир тамгыг сийлжээ. Мөн Хэрлэнгийн савд багтах Худагтын амны хүн чулуунд янгир, иштэй хос онги, сэрээ тамганы хамт [Цогтбаатар нар., 2015: 11-12, 30] тохиолдож байна (хүснэгт-1).

Үүнээс гадна Уйгурын эхэн үед холбогдох Таван толгойн дурсгалд толгойдоо нар (онги)-тай могой, баруун харсан янгир болон гурвалжин тамга [Мөнхтулга, Амараа, Бүрэнтөгс, 2022: 39-42] голлох байр суурьтай байна.

Дээр дурдсан баримтууд нь тус бүс нутаг дахь овог аймгууд тамгаа сийлж үлдээх цаг үед онгин тамгатуудын адил янгир тамгатууд давамгай эрх дархтай байсан нь мэдэгдэнэ. Үүнийг судлаач, доктор Р.Мөнхтулга *тэр үед Эшир Түрэгүүд хэдий хүч харьсан ч Монголын тал нутаг дахь улс төрийн тавцангаас бүрэн зайлуулагдаагүй байсныг илтгэнэ* [Мөнхтулга, Бүрэнтөгс, Арьяажав, 2019: 18] гэж үзсэнтэй бид санал нэг байна.

#### Дүгнэлт

Хэрлэн голын сав газарт орших Суварган дэгт, Чойчингийн нуурын дурсгал нь Түрэгийн язгууртны тахилын онгон болно. Тус хоёр дурсгалыг малтан судалж Түрэгийн язгууртны тахилын онгоны ангилал доторх зарим нэг шинж өөр болохыг тогтоов. Энэ нь язгууртны тахилын онгоны I төрөлд хамаарах тахилын сүмийг III төрөлд илүү хялбар байдлаар босгож байсан. Мөн III төрөлд хамаарах тахилын онгонууд нь далангүй боловч сувагтай болохыг тогтоогоод байна.

Чойчингийн нуурын тахилын онгоны

үнэмлэхүй он цаг нь 740 оны орчимд холбогдож байна. Энэ нь үнэмлэхүй он цаг нь тогтоогдсон цөөн дурсгалын нэг болох бөгөөд хавтант хашлаганы дүрслэл нь энэ үед холбогдох ижил төрлийн дурсгалуудад нэн ховор тохиолдох дундад эртний үеийн язгууртан нүүдэлчдийн өдөр тутмын амьдрал, хэв заншил, эрхлэх аж ахуй, овог аймгийн угсаа хамаарал зэргийг цогц байдлаар харуулж буйд энэхүү дурсгалын хосгүй үнэ цэнэ нь оршино.

Хэрлэн голын сав газрын дээрх нэр бүхий хоёр тахилын онгоны малтлага судалгаа, илэрсэн олдвор, эх хэрэглэгдэхүүн, үнэмлэхүй он цагийн хэлхээс зэрэг нь язгууртны тахилын онгоны судалгааг баяжуулахын зэрэгцээ тухайн үеийн бусад дурсгалуудыг харьцуулан судлахад үнэт хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм. Мөн Түрэгийн язгууртны тахилын онгоны тархац Хэрлэн голын дунд бие хүртэл байсныг дээрх хоёр дурсгал илэрхийлэх бөгөөд VIII зууны дунд үеийн нүүдэлчдийн ертөнц дэх овог аймгуудын улс төрийн нөхцөл байдал, хоорондын харилцаа, эзэмшил газар нутгийн байршил зэрэг олон асуудлыг тодруулах чухал баримт болж байна.

Дээрх хоёр дурсгал нь Монгол орны нутаг дахь Түрэгийн язгууртны тахилын онгоны хамгийн зүүн хойд хязгаарт оршиж байгаа нь судалгааны чухал ач холбогдолтой юм.

### Талархал

Хээрийн малтлага судалгаанд гар бие оролцон ажилласан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Амарболд, Г.Цэнгүүн, Ц.Буянхишиг, Хэнтий аймгийн Соёл, Урлагийн газрын мэргэжилтэн Л.Бүрэнтөгс, Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Жамъян, Хятадын Ардын их сургуулийн докторант М.Барс нарт талархал илэрхийлье. Хээрийн малтлага судалгаа, он цаг тогтоох (C<sup>14</sup>)-д шаардагдах зардлыг МУ-ын Соёлын яам болон Япон улсын Шинжлэх ухааныг дэмжих сан (В төсөл) санхүүжүүлсэн болно.

### Ном зүй

**Батсүрэн, 2009** - Б.Батсүрэн. Өндөр тэрэгтнүүд баэртний Түрэгүүд (VI-IX зуун). Улаанбаатар. - 252 х.

**Батсүрэн, 2015** - Б.Батсүрэн. Гучин Түрэг (otuz türk\otuz türük)-ийн асуудалд. //”Эртний Түрэгийн түүх, соёл”. ОУЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар, тал. 71-101.

**Батсүрэн, Мөнхтулга, 2017** - Б.Батсүрэн, Р.Мөнхтулга. Монголын эртний түүх - IV боть: Түрэг, Уйгур. Улаанбаатар. - 250 х.

**Battulga, 2016** - Ts. Battulga. On the Ancient Turkic arts of stone. //Turkic footprints in Mongolia. Ulaanbaatar, pp. 218-236.

**Баяндэлгэр нар, 2022** - Ч.Баяндэлгэр,

Ц.Одбаатар, Ж.Баярсайхан, Л.Бүрэнтөгс, Ц.Эгиймаа, Дархан Кыдырали, Акедил Тойшанулы, Олжас Шариязданов. Хаяа худаг дахь тахилын онгоны байгууламжийн бүтэц. //Нүүдэлчдийн өв судлал. Tomus XXIII. Fasc-4. Улаанбаатар, тал. 54-69.

**Баяр, 1997** - Д.Баяр. Монголын төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. Улаанбаатар. - 148 х.

**Баяр, 2001** - Д.Баяр. Монгол нутаг дахь хүн чулуун хөшөө. Түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг горилж бичсэн диссертаци. Улаанбаатар. - 220 х.

**Баяр, Эрдэнэбаатар, 1999** - Д.Баяр, Д.Эрдэнэбаатар. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. Улаанбаатар. - 165 х.

**Баяр, Мөнхтулга, Хүрэлсүх, 2008** - Д.Баяр, Р.Мөнхтулга, С.Хүрэлсүх. Олон нуурын хөндийн дурсгал. //ШУАМ. Дугаар 188, № 02. Улаанбаатар, тал. 108-110.

**Билэгт, 2015** - Л.Билэгт. Руни бичгийн дурсгал нүүдэлчин малчдын угсаатны үйл явцыг судлах сурвалж болох нь. //”Эртний Түрэгийн түүх, соёл”. ОУЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар. тал. 68-70.

**Войтов, 1996** - В.Е.Войтов. Древнетюркский пантеон и модель мироздания в культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв. Москва. - 152 с.

**Войтов, Баяр, 1988** - В.Е.Войтов, Д.Баяр. Отчет Хангайского археологического отряда СММКЭ за 1988 г. АХГБСХ. Улаанбаатар.

**Doğan Lütfi, 1954** - Doğan Lütfi. İbni Fadlan Seyahatnamesi. Ankara Üniversitesi İlahiyat Fakültesi Dergisi. 3. sayı, Ankara. - 80 s.

**Кубарев, 2005** - Г.В.Кубарев. Культура древних Тюрков Алтая (по материалам погребальных памятников). Новосибирск. - 400 с.

**Мөнхтулга, 2010** - Р.Мөнхтулга. Бага Хайрханы эртний Түрэг бичээс. //Оюуны хэлхээ. 2010. II. (07). fasc 17. Улаанбаатар, тал. 142-149.

**Мөнхтулга, 2019** - Р.Мөнхтулга. Эртний Түрэгийн язгууртны тахилын онгоны судалгааны зарим асуудлууд. Түүхийн ухааны доктор (F311700)-ын зэрэг горилсон ажил. Улаанбаатар,

**Munkhtulga, 2020** - R.Munkhtulga. An enclosure at the Bilge khagan's memorial complex: Whose is it?. //Altaistics, Turcology, Mongolistics. International Scientific Journal. №1. pp. 41-51. [https://doi.org/10.53042/ATAM/vol1\\_issue1\\_A3](https://doi.org/10.53042/ATAM/vol1_issue1_A3)

**Мөнхтулга, Осава, 2015** - Р.Мөнхтулга, Т.Осава. Донгойн Ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. //”Эртний Түрэгийн түүх, соёл”. ОУЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар, тал. 21-55.

**Мөнхтулга, Бүрэнтөгс, Арьяажав, 2019** - Р.Мөнхтулга, Г.Бүрэнтөгс, Б.Арьяажав. Талын хөшөөний тахилын онгон. Улаанбаатар. - 56 х.

**Мөнхтулга, Амараа, Бүрэнтөгс, 2022** - Р.Мөнхтулга, Д.Амараа, Г.Бүрэнтөгс. Таван толгойн руни бичээс. //Нүүдэлчдийн өв судлал. Том-XXIII, Fasc-3. Улаанбаатар, тал. 35-53.

**Radiocarbon, 2015** - AMS radiocarbon dating report Dongoin shiree site. Institute of Accelerator Analysis Ltd. Fuhushima, Japan, pp. 1-6.

**Radiocarbon, 2017** - AMS radiocarbon dating report Dongoin shiree site. Institute of Accelerator Analysis Ltd. Kanagawa, Japan, pp. 1-5.

**Рогожинский, 2010** - А.Е.Рогожинский. Новые находки памятников древнетюркской эпиграфики и монументального искусства на юге и востоке Казакстана. //Роль кочевников в формировании культурного наследия Казакстана. Научные чтения памяти Н.Э.Масанова: Сб.мат-лов Межд. науч. конф. Алматы. 2010. стр. 335-344.

**Рогожинский, Тишин, 2021** - А.Е.Рогожинский, В.В.Тишин. Тамги династии Ашина в Центральной Азии. // Творец культуры. Материальная культура и духовное пространство человека в свете археологии, истории и этнографии: Сборник научных статей, посвященный 80-летию профессора Дмитрия Глебовича Савинова. Труды ИИМКРАН. Т. LVII. Санкт-Петербург, стр. 582-599. <https://doi.org/10.31600/978-5-907298-22-4.582-599>

**Цогтбаатар нар, 2015** - Б.Цогтбаатар, Г.Лхүндэв, Г.Ангарагдөлгөөн, Т.Осава, Ш.Сайто. Монгол-Японы хамтарсан

“Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. АХГБСХ Улаанбаатар, - 47 х.

**Цогтбаатар нар, 2017** - Б.Цогтбаатар, Н.Эрдэнэ-Очир, Т.Осава, Г.Лхүндэв, Ш.Сайто, Б.Батдалай, Э.Амарболд, Г.Ангарагдөлгөөн. “Донгойн ширээ”-ний дурсгалын археологийн судалгаа. (Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа төслийн 2015-2016 оны малтлага судалгааны үр дүн). Улаанбаатар, - 152 х.

**邱靖嘉, 2021** - 邱靖嘉. 《胡笳十八拍图》所见辽金捺钵凉棚考. 美术研究 ART Research. 2021年第5期. 48-52.


**石見清裕, 2014** - 石見清裕. 羈縻支配期の唐と鐵勒僕固部: 新出「僕固乙突墓誌」から見て. 東方學. 第127輯. 2014年. 1-17.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.






Зураг. 1. Хэрлэн голын сав газраас шинээр илрүүлсэн тахилын онгонууд.



Зураг. 2. Суварган дэгтийн тахилын онгоны дэвсгэр зураг



Зураг. 3. Хүн чулууны орчимд өнгөн хэсгээс илэрсэн ваарын хагархайнууд



Зураг. 6. Чойчингийн нуурын тахилын онгоны дэвсгэр зураг



Зураг. 4. Тахилын хээтэй хавтант хашилаганы үлдэгдэл



Зураг. 7. Чойчингийн нуурын тахилын онгоны хавтант хашилага



Зураг. 5. Суварган дэгтийн хүн чулуу.



Зураг. 8. Олдвор





Зураг. 9. Тонуулчдын ухсан нүхэнд унаж булагдсан хөшөө чулууны хугархай.



Зураг. 11. Суварган дэгтийн хүн чулууны бүс



Зураг. 10. Тахилын онгоны хажуугаас илэрсэн модон шонгийн үлдэгдэл



Зураг. 12. Юстед голын 24-р дурсгалт газрын 13-р бушинаас олдсон бүс







Зураг. 13. Суварган дэгтийн тахилын онгоны цэцгэн хээтэй хавтан чулуу



Зураг. 14. Чойчингийн нуурын тахилын онгоны босоо хавтан чулууны цаасан хэв.



Зураг. 15. Чойчингийн нуурын тахилын онгоны хэвтээ хавтан чулууны цаасан хэв.




Зураг. 17. Өмнөд Кавказтаны нутаг Когалы хэмээх газрын хөшөө чулуун дээрх дүрслэл.




Зураг. 16. Чойчингийн нуурын тахилын онгоны хэвтээ хавтан чулууны гэрэл зураг.



Зураг. 18. "Ху-гийн цуур хэмээх арван найман бадаг" шүлэгт зориулж Мин улсын үеийн нэгэн зураачийн цуврал бүтээл дэх нүүдэлчдийн дүрслэл болон Чойчингийн нуурын тахилын онгоны хавтан чулууны дүрслэл.



Зураг. 19. Суварган дэгтийн тахилын онгоны үнэмлэхүй он цаг.



Зураг. 20. Чойчингийн нуурын тахилын онгоны үнэмлэхүй он цаг.